



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 127


Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах  
тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дах заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:


1. Лансорбид, Ланадексон эмийг сольж хэрэглүүлсний улмаас Эх хүүхдийн эрүүл мэндийн төвд эмчлүүлж буй хүүхдүүдэд мэргэжил аргагүйн тусламж үзүүлэх болон эмийн аюулгүй байдлыг хангах талаар удирдлага менежментийг сайжруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Ажлын хэсгийн санал дүгнэлтийг 2015 оны 04 дүгээр сарын 08-ны дотор удирдлагын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 04 сарын 03 өдрийн  
127 дугаар тушаалын хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн , Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Нарийн бичгийн дарга: Д.Оюунтуяа, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын /ЭМБХЗГ/ Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн мэргэжилтэн
- Гишүүд:
- Л.Зэндмаа, ЭМБХЗГ-ын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- М.Уранчимэг, ЭМБХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- С.Батбаатар, Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
- С.Гантуяа, ЭМБХЗГ-ын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн
- Н.Цогзолмаа, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн
- Ч.Амаржаргал, ЭМБХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн мэргэжилтэн
- Д.Энхжаргал, Эм зүй, эм судлалын ерөнхий мэргэжилтэн
- П.Батхуяг, Хүний эмийн зөвлөлийн Эм судлалын салбар зөвлөлийн дарга